



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 367

Улаанбаатар хот

Г “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам” Ү
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 77.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 339 дүгээр тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоход кумулятив аргыг хэрэглэх тухай журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

САНАЛ ХУРААХ КУМУЛЯТИВ АРГЫГ
ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмаар хувьцаат компани кумулятив аргаар төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэх тохиолдолд энэхүү журмыг баримтлана.

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН БОЛОН
ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОХ

2.1. Кумулятив аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох ердийн болон хараат бус гишүүдийн нийт тоотой тэнцэх хэмжээний саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаанд ногдох энэ санал нь ТУЗ-д эзлэх ердийн болон хараат бус гишүүний эзлэх хувьд хуваагдана.

2.2. Энэ журмын 2.1-т заасан саналаа хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд эзлэх хувьд хуваагдсан хэмжээнд бүгдийг нь нэг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид, эсхүл хэд хэдэн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

2.3. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

Жишээ нь: хувьцаа эзэмшигч А нь “Б” ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно.

2.4. Кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүнийг сонгохдоо энэхүү журмын 2.1, 2.2, 2.3-т заасан журмыг зөрчсөн бол сонгуулын дүнг хүчингүйд тооцно.